

"Хөрс хамгаалал ба Менежментийн зарчим" ном хэвлэгдэн гарлаа



НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төслөөс санхүүжүүлэн хэвлүүлсэн "Хөрс хамгаалал ба Менежментийн зарчим" сурах бичгийг хүлээлгэн өгөх ёслол 12-р сарын 07-ны өдөр Газарзүй геологийн сургуулийн эрдмийн өргөөнд боллоо.

Сурах бичгийг хүлээлгэн өгөх ёслолд МУИС-ийн Эрдэм шинжилгээ инновацийн хэлтсийн дарга проф. Ч.Ганзориг НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн мэргэжилтэн доктор Б.Бүнчингив, “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төслийн менежер Н.Батжаргал, ГГС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор П.Мягмарцэрэн нар болон ГГС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүд, магистрант оюутнууд оролцов.



НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс энэ номны зохиогчийн эрх, орчуулага, редакци, хэвлэлийн бүх зардлийг гаргаж МУИС-ийн магистрын сургалтанд зориулан 400 хувь хэвлүүлсэн байна. "Хөрс хамгаалал ба Менежментийн зарчим" сурах бичиг нь магистрын ахисан түвшний сургалтанд зориулагдсан олон улсын хөрс хамгаалал, сайжруулалтын сүүлийн үеийн судалгааны арга, загварчлал, онолын чиглэлүүдийг багтаасан шинэлэг ном юм. Энэхүү номыг орчуулах болон редакторлахад ГГС-ийн багш нар голлох үүрэгтэй оролцсон юм.

Энэхүү номыг МУИС-ийн номын сан, сургууль, судалгааны төвүүдэд үнэ төлбөргүй өгч байгаа бөгөөд байгаль орчны аль ч салбарын судлаач оюутнууд тус сургуулийн номын сангаар дамжуулан нээлттэй ашиглаж болох юм.